



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/20

Мөрөн сум

**Төрийн албан хаагчдын байрны их засварын
ажлын явцад хяналт тавих, хүлээн
авах комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 03 сарын 27-ний өдрийн А/53 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 05 сарын 02-ний өдрийн 06 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. **“ИХ ХААН ГРУПП”**- ХХК нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Төрийн албан хаагчдын байрны их засварын ажлын тендерт ялж 2025 оны 05 сарын 20-ны өдрөөс 2025 оны 07 сарын 04 -ний дотор хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан тул уг ажлын явцад хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хүлээн авах эрх бүхий сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Комиссын дарга: Г.Загдхорол Нийгмийн бодлогын түшмэлийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичиг: Г.Хишигбаатар Хууль эрх зүйн мэргэжилтэн
Гишүүдэд:

Э.Балчиндорж Цагаан толгой багийн Засаг дарга
Ц.Болорцэцэг ХЖДҮХ мэргэжилтэн
А.Энхтөр Аж ахуйн нярав

2. **“ИХ ХААН ГРУПП”** ХХК -с хүлээн авах “Төрийн албан хаагчдын байрны их засварын ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн өнгө үзэмж, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, гүйцэтгэлийг фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Г.Загдхорол) -д үүрэг болгосугай.

3. Засварын үйл ажиллагаанд захиалагчийн зүгээс хөндлөнгийн хяналт хийхдээ Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагааныхаа чиглэлээр Аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай нягт хамтарч ажиллахыг комиссын нийт гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ